



**БАЯНХОНГОР АЙМАГ
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ,
ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 2/44

Номгон

Г Д.Балданг тасалбар түгээврийн кассаар Г
томилон цалинжуулах тухай


Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 18.1.1, 48.2, 48.3.2, 62.1 дүгээр заалт, Хамтын гэрээний 2.2 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын нийт ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж, тухайн орон тооны албан тушаалын чиг үүрэг, ажлын байрны онцлогт дүн шинжилгээ хийсний дагуу кассын няраваар ажиллаж байгаа Д.Балданг 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тасалбар түгээврийн кассаар томилж, Хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2.Тасалбар түгээврийн касс Д.Балданг 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ТҮ-2 дугаар зэрэглэлийн 5 дугаар шатлалаар цалинжуулж, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг жижүүрийн үндсэн цалингийн 40 хувиар бодож олгохыг нягтлан бодогч Д.Ганхуягт зөвшөөрсүгэй.

3.Албан тушаалын тодорхойлолттой сайтар танилцаж, тасалбар түгээврийн кассын үүрэгт ажлыг чанартай гүйцэтгэж, орлогыг тухай бүрт байгууллагын дансанд төвлөрүүлэн, өр авлагагүй ажиллаж, кассын тайланг цаг хугацаанд нь санхүүд тайлагнаж байхыг тасалбар түгээврийн касс Д.Балданд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ПҮРЭВДАГВА

2519040